



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

993 оны 11 сарын 09 өдөр

Дугаар A/607

Мандалговь

Ойн зурvas хүлээн авах  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.9 дэх заалт, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд, Сангийн сайдын 2013 оны А-96/71 тоот тушаалын хавсралтаар баталсан "Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах, санхүүжүүлэх, таримал ойг үнэлэх, улсын ойн санд худалдан авах, өмчлүүлэх журам"-ын 3.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, аймгийн Засаг даргын 2023 онд байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах 23-10 гэрээнд тусгагдсан ойжуулалт, ойн зурvas байгуулах ажлын хүрээнд Улсын төсвийн хөрөнгөөр Сайхан-Овоо суманд 5 га, орон нутгийн хөрөнгөөр Дэлгэрцогт, Говь-Угаал сумдад тус тус 5 га нийт 10 га талбайд хийгдсэн ойн зурvasын ажлын гүйцэтгэлийг шалган хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Н.Гантулга (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

Гишүүд: М.Ганчимэг (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

П.Уртнасан (Сум дундын ойн ангийн даргын албан Үүргийг түр орлон гүйцэтгэгч)

У.Сүнжидмаа (Говь-Угаал сумын Засаг даргын Тамгын газрын дарга)

Ц.Тунгалаг (Сайхан-Овоо сумын байгаль орчин хариуцсан мэргэжилтэн)

Б.Баттогтох (Дэлгэрцогт сумын байгаль орчин хариуцсан мэргэжилтэн)

Д.Хаянхярваа (Дөл судар ХХК-ний захирал)

Нарын бичгийн дарга: Б.Цэрэнсугир (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн)

2. Ойжуулалт, ойн зурваст тарьж ургуулсан тарьц, суулгацын амьдралтын хувь хэмжээг тогтоож, акт, танилцуулгыг 2023 оны 11 дүгээр сарын 15-ны дотор холбогдох газруудад хүргүүлэхийг ажлын хэсэг /Н.Гантулга/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МОНХБАТ

48103112-

ОЙЖУУЛАХ, ОЙН ЗУРВАС БАЙГУУЛСАН АЖЛЫН  
ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХҮЛЭЭН АВАХ АКТ

2023 оны 11 дүгээр сарын 06

Дугаар 01

Дундговь аймгийн Засаг даргын 2023 оны А/607 дугаар захирамжаар томилогдсон 2023 оны ойн зурвасын ажлыг шалгаж хүлээн авах ажлын хэсэг “Дөл судар” ХХК-ний гүйцэтгэсэн Сайхан-Овоо суманд 5 га талбайд /иргэн, аж ахуйн нэгж, байгууллага/-ын ногоон зурvas байгуулсан ажлын хэмжээ, чанар, үр дүнг газар дээр нь шалгаж үзэхэд:

**Сайхан-Овоо сумын төвд /газрын нэр/ сав газрын 5 га талбайд 2023 оны 5-р сарын 19-ны өдрөөс 23-ны өдрийн хооронд хайлаас 2650, улиас 180, бургас 120, сухай 50 ширхэгийг нийт 3000 ш тарьц суулгац тарьжээ. /суулгацын нэр төрөл тоо/**

Нэг га талбайд /тарьц суулгацын тоо/ 600 хэмжээгээр анх тарьж суулгаснаас хойш 2023 оны 11-р сарын 06-ны өдөр, намрын тооллогоор 1 га-д 540 ширхэг, нийт талбайд 2700 ширхэг таримал ургасан байв. Таримлын жилийн өсөлт 15-30 см, ерөнхий байдал хэвийн амьдралтын түвшин 90,0 хувь байв.

-Хамгаалалтын хашаа 480 м урт, 150 м өргөн 5 га талбайд баригдаж, хамгаалалтын үүргээ сайн гүйцэтгэсэн. /гүйцэтгэж байгаа эсэх/

-Ногоон зурвасын талбайд 1 ш худаг, усжуулах систем хийгдэж ~~хийд~~ хэвийн ажилтай эсэх/

-Харуул хамгаалалтын байдал **хайс хашаатай** /шаардлага хангасан эсэх/

-Усалгаа, арчилгаа **тогтмол сайн** /шаардлага хангасан эсэх/

-Ногоон зурваст ажиллаж байгаа техник, тоног төхөөрөмжийн нэр төрөл тоо хэмжээ **усалгааны шланктай**


Ногоон зурvas байгуулсан ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн тайлан мэдээ, газар дээр нь явуулсан тооллого, судалгаанаас үндэслэн ажлын хэсгээс **ТОГТООХ НЬ**:

1. Дундговь аймгийн “Дөл судар” ХХК-/байгууллага, аж ахуйн нэгж/-ын 2023 онд гүйцэтгэсэн ой нөхөн сэргээх ажлын хэмжээ 5 га, эхний жилдээ 1 га-д 540 ширхэг, нийт талбайд 2700 ширхэг таримал мод ургасан болохыг тогтоов.

2. Гүйцэтгэлийн хэмжээ, чанар, үр дүнгийн байдлыг үндэслэн ойжуулах ажилд зарцуулсан хөрөнгийн санхүүжилтийг Улсын төсвийн хөрөнгөөр 100 хувиар буюу 56250,0 мян, төгрөгөөр олговол зохибоос урьдчилгаагаар олгосон 39375,0 мян, төгрөгийг хасч эцсийн санхүүжилтийг 16875,0 мян, төгрөгөөр хийхийг зүйтэй гэж үзэв.


3. Ажлын хэсгээс өгөх зөвлөмж, санал: Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний зардлын нормативыг шинэчлэн батлах тухай Байгаль орчин, аялал жуулчлалын сийд, Сангийн сайдын хамтарсан А/172, 116 дугаар тушаалыг үндэслэн хамгаалалтын ойн зурвасын арчилгааны зардлыг 2024 оноос эхлэн 3 жилийн хугацаатай олгохыг ажлын хэсгээс санал болгож байна. Өвөл хавартаа хүүхэд мод хугалж гэмтээх, туулай орохоос болгоомжилж хамгаалах. Мөн цэнэг усалгааг сайн хийх.

АКТ ТОГТООСОН:  
АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА  
ГИШҮҮД



Н.Гантулга  
М.Ганчимэг  
Б.Цэрэнсугир  
П.Уртнасан  
Ц.Тунгалаг

Зөвшөөрсөн:



Д.Хаянхярваа

Жишиг талбарт явуулсан тооллогын хүснэгт<sup>1</sup> 2

Жишиг талбайн дугаар	Жишиг талбайн хэмжээ м <sup>2</sup>	Анх тарьс ан тоо /шир/	Ургаж байгаа модны тоо /шир/	Хорогдсон модны тоо /шир/	Үүнээс:			
					Өвчин хортонос	Мал амьтад идсэн	Технологи хангагүй	Цаг уурын онцгой шалтгаа -наар
I талбай	200	16	11	5			5	
II талбай	200	17	13	4			4	
III талбай	200	15	10	5			5	
IV талбай	200	15	12	3			3	
V талбай	200	16	13	3			3	
VI талбай	200	18	14	4			4	
VII талбай	200	17	15	2			2	
VIII талбай	200	15	13	2			2	
IX талбай								
X талбай								
Тооллогын дүн:								
-Бүх жишиг талбайн хэмжээгээр								
- Нэг га-д шилжүүлснээр		600	540	60			60	
-Нийт талбайд		3000	2700	300			300	

Тайлбар, дүгнэлт: Ургалт 90,0 хувьтай. Өвөл хавартаа мод хугалж гэмтээх, туулай орохоос болгоомжилж хамгаалах. Мөн цэнэг усалгааг сайн хийх


ТООЛЛОГО ЯВУУЛСАН:

АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА  
ГИШҮҮД



Н.Гантулга  
М.Ганчимэг

Б.Цэрэнсугир  
П.Уртнасан  
Ц.Тунгалаг



Зөвшөөрсөн  
/гүйцэтгэгч/

Д.Хаянхяраа